

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 26 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 26/21

Улаанбаатар хот

Гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх, томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.7 дахь заалт, Гүйцэтгэх захирал Э.Алтанзулын өөрийн хүсэлт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Гүйцэтгэх захирал Энхсайханы Алтанзулыг өөрийнх нь хүсэлтээр 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Чинбатын Одонгэрэлийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.
3. Гүйцэтгэх захирал Э.Алтанзулын ажил хүлээлцэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Үйл ажиллагаа хариуцсан захирал /А.Хонгорзул/-д даалгасугай.
4. Албан тушаалын өөрчлөлттэй холбогдуулан компанийн нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ч.Одонгэрэлд олгосугай.
5. Удирдлагын өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, харилцагч банкууд болон бусад байгууллагуудад мэдэгдэж, гэрээ, баримт бичигт өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Ч.Одонгэрэл/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Т.Цацрал/ нарт тус тусын чиг үүргийн дагуу даалгасугай.
6. Санхүүгийн зохицуулах хорооноос Ч.Одонгэрэлийг Гүйцэтгэх захирлаар томилох зөвшөөрөл ирсэн тохиолдолд тухайн өдрөөс эхлэн түүнийг Гүйцэтгэх захирлаар томилогдсонд тооцсугай.
7. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ч.Одонгэрэлтэй хөдөлмөрийн гэрээний нөхцөл, цалин урамшууллыг тохиролцож, ТУЗ-ийн нэрийн өмнөөс гэрээ байгуулахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.
8. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25/32 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
9. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.

